

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/12/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Ч.Мөнхтогтох
Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТАРИАЛАН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.БАТЗУЛ ТАНАА

2023.02.18 № УВА-2023/НА-СТА-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200412

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,150,945.00	783,100.00
33	АВЛАГА	22,845.00	00.00
335	Бусад авлага	22,845.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	22,845.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,128,100.00	783,100.00
354	Хангамжийн материал	1,128,100.00	783,100.00
35410	Бичиг хэргийн материал	528,100.00	56,600.00
35470	Бусад хангамжийн материал	600,000.00	726,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,528,853.97	3,163,979.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,528,853.97	3,163,979.33
392	Биет хөрөнгө	1,528,853.97	3,163,979.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,000,000.00	-16,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,856,785.00	5,650,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,722,410.18	-2,724,999.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,850,150.00	1,313,850.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,461,524.85	-1,080,724.81
39217	Ном	5,854.00	5,854.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,679,798.97	3,947,079.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,679,798.97	3,947,079.33
51	Засгийн газрын хувь оролцоо	2,679,798.97	3,947,079.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	23,238,888.00	23,238,888.00
51101	Өмч: - төрийн	23,238,888.00	23,238,888.00
512	Хуримтлагдсан үр дүн	-20,795,637.70	-19,308,824.67
51210	Өмнөх үеийн үр дүн	-20,795,637.70	-20,576,105.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,267,280.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	236,548.67	17,016.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,679,798.97	3,947,079.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	76,670,300.00	78,260,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,670,300.00	77,760,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,855,300.00	77,760,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,855,300.00	77,760,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	76,831,392.00	76,993,019.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,831,392.00	76,993,019.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,257,279.00	69,582,977.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,056,735.00	45,246,948.54
210101	Үндсэн цалин	30,943,595.00	28,358,961.47
210102	Нэмэгдэл	00.00	3,862,535.47
210104	Урамшуулал	14,113,140.00	13,025,451.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,774,525.00	5,608,113.00
210201	Тэтгэврийн даатгал	4,022,045.00	3,845,994.87
210202	Тэтгэмжийн даатгал	450,572.00	452,468.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	360,455.00	361,975.47
210204	Ажилгүйдлийн даатгал	85,585.00	86,152.17
210205	Эрүүл мэндийн даатгал	855,868.00	861,521.72
2104	Хангамж, бараа материалын зардал	5,696,130.00	7,228,520.00
210401	Бичиг хэрэг	1,072,100.00	1,117,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,624,030.00	6,098,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	12,000.00
2107	Томилолт, зочны зардал	370,000.00	312,000.00
210702	Дотоод албан томилолт	370,000.00	312,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,089.00	1,346,321.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,040.00	1,014,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,249.00	95,749.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	9,072.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	278,800.00	137,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,794,800.00	9,841,074.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,269,700.00	1,190,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,638,600.00	7,586,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	886,500.00	1,064,874.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,574,113.00	7,410,042.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,613,200.00	1,615,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	1,615,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,960,913.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,960,913.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,794,642.46

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,794,642.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-161,092.00	1,267,280.36
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-161,092.00	1,267,280.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	76,670,300.00	77,760,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,670,300.00	77,760,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,855,300.00	77,760,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,855,300.00	77,760,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	76,670,300.00	77,760,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,670,300.00	77,760,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,096,187.00	70,350,257.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,659,299.00	45,246,932.54
210101	Үндсэн цалин	30,546,158.00	27,287,149.82
210102	Нэмэгдэл	00.00	4,934,334.72
210104	Урамшуулал	14,113,141.00	13,025,448.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,797,369.00	5,585,284.00
210201	Тэтгэврийн даатгал	4,044,889.00	3,823,160.47
210202	Тэтгэмжийн даатгал	450,572.00	452,469.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	360,455.00	361,975.47
210204	Ажилгүйдлийн даатгал	85,585.00	86,152.17
210205	Эрүүл мэндийн даатгал	855,868.00	861,526.40
2104	Хангамж, бараа материалын зардал	4,350,450.00	6,683,020.00
210401	Бичиг хэрэг	882,750.00	572,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,467,700.00	6,098,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	12,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	2,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	2,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	370,000.00	312,000.00
210702	Дотоод албан томилолт	370,000.00	312,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,165,089.00	1,520,321.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	643,040.00	1,188,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,249.00	99,249.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	5,572.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	278,800.00	137,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,253,980.00	8,802,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,253,980.00	1,003,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	7,799,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,574,113.00	7,410,042.46

2132	Бусад урсгал шилжүүлэг	7,613,200.00	1,615,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	1,615,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,960,913.00	5,794,642.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,960,913.00	5,794,642.46
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	23,238,888.00	236,548.67	-20,795,637.70	2,679,798.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,238,888.00	236,548.67	-20,795,637.70	2,679,798.97
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	23,238,888.00	236,548.67	-20,795,637.70	2,679,798.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	219,532.67	219,532.67
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,238,888.00	236,548.67	-20,576,105.03	2,899,331.64
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-219,532.67	00.00	-219,532.67
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,267,280.36	1,267,280.36
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,238,888.00	17,016.00	-19,308,824.67	3,947,079.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,760,300.00	71,965,657.54	5,794,642.46	92.5
УРСГАЛ ЗАРДАЛ	77,760,300.00	71,965,657.54	5,794,642.46	92.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,093,700.00	70,350,257.54	5,743,442.46	92.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,909,700.00	45,246,932.54	662,767.46	98.6
Үндсэн цалин	30,846,100.00	27,287,149.82	3,558,950.18	88.5
Нэмэгдэл	0	4,934,334.72	4,934,334.72	-
Урамшуулал	15,063,600.00	13,025,448.00	2,038,152.00	86.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,738,700.00	5,585,284.00	153,416.00	97.3
Тэтгэврийн даатгал	3,902,300.00	3,823,160.47	79,139.53	98.0
Тэтгэмжийн даатгал	459,100.00	452,469.49	6,630.51	98.6
ҮОМШӨ-ний даатгал	367,300.00	361,975.47	5,324.53	98.6
Ажилгүйдлийн даатгал	91,800.00	86,152.17	5,647.83	93.8
Эрүүл мэндийн даатгал	918,200.00	861,526.40	56,673.60	93.8
Хангамж, бараа материалын зардал	7,700,400.00	6,683,020.00	1,017,380.00	86.8
Бичиг хэрэг	583,200.00	572,200.00	11,000.00	98.1
Тээвэр, шатахуун	6,834,000.00	6,098,820.00	735,180.00	89.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	283,200.00	12,000.00	271,200.00	4.2
Эд хогшил, урсгал засварын зардал	2,200,000.00	2,200,000.00	0.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	2,200,000.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	360,200.00	312,000.00	48,200.00	86.6
Дотоод албан томилолт	360,200.00	312,000.00	48,200.00	86.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,045,600.00	1,520,321.00	525,279.00	74.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,193,400.00	1,188,000.00	5,400.00	99.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	90,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	100,000.00	0	100,000.00	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	101,000.00	99,249.00	1,751.00	98.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	5,572.00	24,428.00	18.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	531,200.00	137,500.00	393,700.00	25.9
Бараа үйлчилгээний бусад зардал	12,139,100.00	8,802,700.00	3,336,400.00	72.5
Бараа үйлчилгээний бусад зардал	4,306,100.00	1,003,500.00	3,302,600.00	23.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,833,000.00	7,799,200.00	33,800.00	99.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,666,600.00	1,615,400.00	51,200.00	96.9
Бусад урсгал шилжүүлэг	1,666,600.00	1,615,400.00	51,200.00	96.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,600.00	1,615,400.00	51,200.00	96.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,760,300.00	77,760,300.00	0.00	100.0

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	77,760,300.00	77,760,300.00	0.00	100.0
Орон нутгийн төсвөөс	77,760,300.00	77,760,300.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,267.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	22.8	0.0	-22.8
Бараа материал	1,128.1	783.1	-345.0
Үндсэн хөрөнгө	1,528.8	3,163.9	1,635.1
Нийт хөрөнгө	2,679.7	3,947.0	1,267.3
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,679.7	3,947.0	1,267.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,679.7	3,947.0	1,267.3

Бараа материалын дансны үлдэгдэл 783.1 мянган төгрөг болж 345.0 мянган төгрөгөөр буурсан нь байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,163.9 мянган төгрөг болж 1,635.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тоног төхөөрөмж худалдаж авч дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,947.0 мянган төгрөг болж 1,267.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 83,563.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийн зардлыг 5,803.4 мянган төгрөгөөр бууруулж 77,760.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналыг үндсэн үйл ажиллагааны зардлыг 77,760.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 77,760.3 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 77,760.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 71,965.6 мянган төгрөг буюу 92.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 5,794.6 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	53,647.7	51,828.3	1,819.4	96.6
2	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,193.4	1,193.0	0.4	100.0
3	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	1,666.6	1,615.4	51.2	96.9
4	Иргэдийн нийтийн хурлын урамшуулал	16,946.5	16,325.5	621.0	96.3
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	4,306.1	1,003.5	3,302.6	23.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 09/03 дугаар тогтоолыг үндэслэн Тариалан сумын ИТХ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/12 захирамжаар ажлын хэсэг байгуулан халуун усны хуучин барилга актлах шийдвэр гарч дуудлага худалдааны бүртгэл, дэнчингийн мөнгө 19.2 сая төгрөгийг төвлөрүүлж буцаан гаргасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022

оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 73.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 89.4 сая төгрөгийн 1 хувиар буюу 0.9 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроож 5, хугацаандаа 144 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Ч.МӨНХТОГТОХ/

2023 оны 02 дугаар сарын 23-ны өдөр